



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.
Чингисийн өргөн чөлөө. Засгийн газрын XIV байр.
Утас: 51-263051. Факс: (976) 7004-3479
E-mail: info@energy.gov.mn

2021. 02. 12 № a/835
танаа 2021. 02. 26-ны № 05-т

Г Хариу хүргүүлэх тухай Г

Эрхэм Улсын Их Хурлын гишүүн танд энэ өдрийн мэндийг хүргзэе.

Танаас ирүүлсэн асуултад дараах хариултыг хүргүүлж байна. Үүнд:


1.Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах ажлын хүрээнд "Дэвшилтэт эко түлш" ХХК-аас сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулан Эрчим хүчин яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулахаар ирүүлсэн боловч тус ТЭЗҮ-д техник технологийн сонголтын тооцоо, эдийн засгийн тооцоо хийгдээгүй учир шаардлага хангагүй буцаагдсан болно. Хөшөөтийн нүүрсний уурхайг түшиглэн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах талаар Эрчим хүчин яамны зүгээс үйлдвэр барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулсан бөгөөд ТЭЗҮ батлагдсаны дараа Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулна.

2.Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийн барилга угсралтын ажлыг 2021 онд багтаан эхлүүлэхээр ажиллаж байна. Батлагдсан төсвийн дагуу үйлдвэрийг 2022-2023 оны халаалтын улиралд багтаан эхний эзлжийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

3.Үйлдвэр нь жилд 50,000-90,000 тонн сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр байна. Энэ нь Ховд хотын гэр хорооллын 7960 айл өрхийн хэрэглээг бүрэн хангах хэмжээ болно. Түлшний жишиг хэмжээг нийслэлийн гэр хорооллын нэг өрхийн хэрэглээгээр тооцсон. Цаашид үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, бус орон нутгийн хэрэгцээг хангах болно.

4.Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр ашиглалтад орсноор аймгийн төв, сум суурин газрын агаарын бохирдлыг 50 хувиар бууруулна гэж тооцоолж байна. Гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр жигд хүртээмжтэй хангах үүднээс Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн цахим картын системийг нэвтрүүлэх боломжтой.

Цаашид Засгийн газрын мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгагдсан эрчим хүчиний салбарт хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын явц байдал болон холбогдох мэдээ мэдээллүүдийг хүргүүлж хамтран ажиллахаа илэрхийлье.



Н.ТАВИНБЭХ

170600556